



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 45 (474)

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *"40 000 орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлэх мастер төлөвлөгөө*
- *Түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах талаар авах зарим арга хэмжээний тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2006 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2006 оны арванхоёрдугаар сарын 7

№45 (474)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

662.	Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийг томилох тухай	Дугаар 88	1289
------	--	-----------	------

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

663.	Мастер төлөвлөгөө батлах тухай	Дугаар 200	1289
664.	Төрийн өмчит хуулийн этгээд байгуулах тухай	Дугаар 266	1315
665.	Орон сууцны үндэсний төвийг татан буулгах тухай	Дугаар 267	1315
666.	Хөрөнгө гаргах тухай	Дугаар 268	1316
667.	Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах талаар авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 269	1316
668.	Ажилд томилох тухай	Дугаар 274	1316

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 11 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 88

Улаанбаатар
хот

Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийг томилох тухай

Монгол Улсын Төв банк /Монголбанк/-ны
тухай хуулийн 26 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийг
үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчөөр
Батсүхийн Энххуягийг томилсугай.

2. Энэ тогтоолыг 2006 оны 11 дүгээр сарын
30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 8 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 200

Улаанбаатар
хот

Мастер төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:
1. Засгийн газрын 2005 оны 144 дүгээр
тогтоолоор батлагдсан "40000 орон сууц"
хөтөлбөрийг хэрэгжүүлэх мастер төлөвлөгөөг 1
дүгээр хавсралт ёсоор баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, удирдлага
зохион байгуулалт, зээл, санхүүгийн асуудлыг
цогцоор шийдвэрлэх үүрэг бүхий "Орон сууцны
санхүүжилтийн корпораци" компанийг 2006 оны Ш
улиралд багтаан байгуулах арга хэмжээг зохих

журмын дагуу авахыг Сангийн сайд Н.Баяртсайхан, Барилга, хот байгуулалтын сайд Ж.Наранцацралт, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Ц.Батбаяр нарт даалгасугай.

3. Хөтөлбөрийг 2006-2009 онд хэрэгжүүлэхтэй уялдуулан орон сууц, түүний дэд бүтэц, нийгэм, соёлын барилга байгууламжийг барьж байгуулахад шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөв, бусад хөрөнгийн эх үүсвэрээс шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Н.Баяртсайхан, Барилга, хот байгуулалтын сайд Ж.Наранцацралт, Түлш, эрчим хүчний сайд Б.Эрдэнэбат, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ө.Энхтүвшин, Эрүүл мэндийн сайд Л.Гүндалай, Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд Ц.Цэнгэл нарт даалгасугай.

4. Шинэ хотхон, хороолол барих зарим газрыг улсын тусгай хамгаалалттай нутаг дэвсгэрийн харьяаллаас гаргах асуудлыг судлан зохих журмын дагуу шийдвэрлүүлэх арга хэмжээ авахыг Байгаль орчны сайд И.Эрдэнэбаатар, Барилга, хот байгуулалтын сайд Ж.Наранцацралт нарт даалгасугай.

5. Мастер төлөвлөгөөнд тусгагдсан шинэ хотхон, хороолол баригдах газрын хэмжээ, байршил, эзэмшигчийг тогтоож, зураг төсөл боловсруулахыг Барилга, хот байгуулалтын сайд

Ж.Наранцацралт, аймаг, нийслэлд баригдахаар төлөвлөгдсөн орон сууцны газрын асуудлыг 2006 оны Ш улиралд багтаан шийдвэрлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

6. "40000 орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлэх Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг "Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн тухай" Засгийн газрын 2005 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 66 дугаар тогтоолын 21 дүгээр хавсралт болгон 2 дугаар хавсралт ёсоор баталсугай.

7. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан "40000 орон сууц" хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 2005 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 144 дүгээр тогтоолын 5 дугаар зүйл, "Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн тухай" Засгийн газрын 2005 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 66 дугаар тогтоолын 17 дугаар хавсралтын 40 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
САЙД Ж.НАРАНЦАЦРАЛТ

Засгийн газрын 2006 оны 200 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

"40 000 ОРОН СУУЦ" ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. "40 000 орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлэх мастер төлөвлөгөөний зорилго нь хот байгуулалтын оновчтой бодлого хэрэгжүүлэх, газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах, орон сууцны урт хугацаатай эзэлийн тогтолцоог бий болгох, барилгын салбарт эдийн засаг, эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх, гэр хороолол болон хотын захын ашиглалтгүй байгаа талбайд орон сууцны дэд бүтцийг барьж байгуулах зэргээр иргэдийн худалдан авах чадвар, шаардлагад нийцсэн ортог, чанар бүхий 40000 орон сууц барих нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн удирдлага, зохион байгуулалтын цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд оршино.

1.2. Энэхүү мастер төлөвлөгөө нь Засгийн газрын 2005 оны 144 дүгээр тогтоолоор батлагдсан "40 000 орон сууц" хөтөлбөрийн үйл ажиллагааны хамрах хүрээ, хугацаа, шаардагдах хөрөнгө оруулалт, хэрэгжүүлэх байгууллагын үүрэг хариуцлагыг нэрийнчлэн тусгасан баримт бичиг юм.

1.3. Мастер төлөвлөгөө нь хотын барилгажсан хэсгийн нягтралыг сайжруулах, гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбох замаар орон сууц болон орон сууцны шинэ хотхон, хороолол, түүний дэд бүтэц (цэвэр, бохир ус, дулаан, цахилгаан, зам гэх мэт)-ийг барих газрын байршлыг тогтоож, тэдгээрт шаардагдах хөрөнгийг хэмжээ, эх үүсвэрийг шийдвэрлэхэд чиглэгдэнэ.

Хоёр. Орон сууцаар хангах стратеги, зорилт, үйл ажиллагаа

Мастер төлөвлөгөөний баримтлах зарчим,
стратег

2.1. Мастер төлөвлөгөө нь хүний төлөө чиглэсэн зорилготой, байгаль орчин, нөөц баялгаа хамгаалсан, эдийн засгийн өсөлт болон нийгмийн хөгжилтэй нийцсэн хүн төвтэй, тогтвортой хот байгуулалтын зарчимд үндэслэнэ.

2.2. Мастер төлөвлөгөөнд стратегийн дараахь үндсэн таван зорилтыг тусгасан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

-стратеги 1. Орон сууцны шинэ хотхоны байгуулна;

-стратеги 2. Улаанбаатар болон төв, суурин газарт орон сууцны нягтралыг сайжруулна;

-стратеги 3. Гэр хорооллыг хөгжүүлнэ;

-стратеги 4. Орон сууцны хөрөнгийн зах зээлийн харилцааг хөгжүүлнэ;

-стратеги-5. Барилгын материалын үйлдвэрлэл, боловсон хүчний чадавхийг дамжин.

2.3. Стратеги-1 хэрэгжсэнээр Улаанбаатар хотын 2020 он хүртэлх ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хотын захын ашиглагдаагүй газарт орон сууцны шинэ хотхон, хорооллыг 2009 он хүртэлх хугацаанд барьж байгуулах ба цаашид үргэлжлүүлэх инженерийн хангамжийн бэлтгэлийг хангана.

2.4. Стратеги-2 хэрэгжсэнээр Улаанбаатар хотын орон сууцны нягтралыг сайжруулах замаар одоогийн ашиглагдаж байгаа инженерийн хангамжийн ашиглалтыг сайжруулах, боломжтой нөөцийг ашиглан нийтийн зориулалттай орон сууцыг барина.

2.5. Стратеги-3 хэрэгжсэнээр Улаанбаатар хот болон төв, суурин газрын гэр хороололд цэвэр, бохир ус хангамжийн төвлөрсөн болон төвлөрсөн бус системд холбогдсон өртөг багатай амины тохилог орон сууцыг барина.

2.6. Стратеги-4 хэрэгжсэнээр орон сууцны хөрөнгийн зах зээл хөгжин, орон сууцны зээл, хадгаламжийн тогтолцоо бий болж иргэдийн орон сууцанд амьдрах, эзэмших, өмчлөх эрх баталгаажина.

2.7. Стратеги-5 хэрэгжсэнээр барилгын материалын үйлдвэрлэл, техник, технологийн хангамж сайжирч, тус салбарыг мэргэжлийн боловсон хүчээр тогтвортой хангах тогтолцоо бий болно.

3. Стратеги-1. Орон сууцны шинэ хотхоныг байгуулна.

Энэ зорилт, үйл ажиллагааны хүрээнд:

3.1. Энд дор дурдсан зорилтуудыг тавьж байна:

-зорилт 1. Шинэ хотхон, хорооллын зураг төсөл, техникийн нөхцөлийг бүрдүүлнэ;

-зорилт 2. Шинэ хотхон, хорооллын дэд бүтцийг байгуулах;

-зорилт 3. Шинэ хотхон, хорооллыг барих;

-зорилт 4. Шинэ хотхон, хороололд шинэ техник, технологи нэвтрүүлэх.

3.2. Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан ашиглагдаагүй байгаа газарт шинээр орон сууцны хотхон, хороолол байгуулахаар төлөвлөсөн бөгөөд 2009 он дуустал хугацаанд Баянголын ам, Яармаг, Баянзүрх, Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт баригдах шинэ хотхон, хорооллуудын дэд бүтцийг байгуулан орон сууц барина. Цаашид 2020 он хүртэл Улаанбаатар хотод Нисэх, Төмөр замын 361-ийн гарам, Эмээлт, Өлзийт, Туул, Налайх, Багануур зэрэг газарт шинэ орон сууцны хороолол барихаар төлөвлөж байна.

3.3. Зорилт 1. Шинэ хотхон, хорооллын зураг, төсөл техникийн нөхцөлийг бүрдүүлнэ.

Шинэ хотхон, хорооллын орон сууцны зураг төслийг боловсруулахдаа орчин үеийн техник, технологийн ололт амжилтыг өргөнөөр ашиглах ба хот төлөвлөлтийн шинэлэг зарчим, арга зүй, норм, норматив, стандартыг боловсруулж мөрдөнө.

Улаанбаатар хотын 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний дагуу зураг 1-д харуулсан байршилд баригдах орон сууцны шинэ хотхон, хорооллын зураг төслийг /хүснэгт 1/ зохих журмын дагуу боловсруулж батлуулна.


Хүснэгт 1. Шинэ хотхон, хорооллын зураг төсөл

Д/д	Хорооллын нэр	Хариуцах байгууллага	Тайлбар	
1.	Баянголын амины хотхонууд	Баянгол хотхон	Нийслэлийн хот төлөвлөлт, эрдэм шинжилгээ, зураг төслийн хүрээлэн /НХТЭШЗТХ/	Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлагдсан
2.		Орбит хотхон	"Донхва-УБ" ХХК /БНСУ/	Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлагдсан
3.		ШУТИС хотхон	ШУТИС	Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлагдсан
4.		Мянганы хотхон	"Москва Комплекс" ХХК	Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлагдсан
5.	УБ хотын "Шинэ төв"	НХТЭШЗТХ	2006 онд батлуулна	
6.	"4 Улирлын цэцэрлэг" хороолол	"Суруга Монгол" ХХК	Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлагдсан	
7.	Яармаг шинэ хотхон	НХТЭШЗТХ	2006 онд батлуулна	
8.	Маршал цогцолбор	"Эко Констракшн" ХХК	Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлагдсан	
9.	Нархан цогцолбор	"Алтай Констракшн" ХХК	Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлагдсан	

Хүснэгт 2. Улаанбаатар хотын шинэ хотхон, хорооллуудын орон сууцны барилгажилт

№	Хорооллын нэр	Байршил	Газрын хэмжээ /га/	Орон сууцны		Хөрөнгө оруулалт /томгосгон/ /сая төвг/			
				Тоо /айл/	Даяхар	Дэд бүтэц	Орон сууц	Нийгмийн үйлчилгээ	Бүгд
1.	Баянгол хотхон		79	3400	2-16	6360,0 улсын төсөв	74200,0	4640,0	85200,0
2.	Орбит хотхон		41	1050	2-12	3740,0 улсын төсөв	26550,0	880,0	31170,0
3.	ШУТИС хотхон	Баянголын ам	48	655	2-3	3410,0 улсын төсөв	131240,0	1000,0	135650,0
4.	Мянгалын хотхон		91	1000	1-3	5885,3 улсын төсөв	81000,0	1260,0	88145,3
5.	УБ хотын "Шинэ төв"	СХД 20-р хороо	770	12500	1-9	64410,0 улсын төсөв	187500,0	16297,0	268207,0
6.	Баянзүрх АОС хороолол	УБ, Налайхын авто замын хойно	150	1800	2-4	30495,8 улсын төсөв	28630,0	3603,6	62738,4
7.	4 Улирлын цацарлаг хороолол	ХУД 1, 11-р хороо	90	3300	2-12	62400,0 гадаад	218400,0	31200,0	312000,0
8.	Яармаг шинэ хотхон	ХУД 14-р хороо	970	23900	2-12	191400,0 гадаад	248688,0	42912,0	483000,0
9.	Маршал цогцолбор	ХУД 11-р хороо	20	1650	2-12	2178,0 гадаад	69000,0	990,0	72168,0
10.	Нархан цогцолбор	ХУД 11-р хороо	1,98	390	3-5	хувийн	955,2	238,8	1194,0
			2260,98	49645		382279,1	1066165	103021,4	1539472,7

НИЙТ



Улаанбаатар хотод баригдах шинэ хотхон, хорооллын цахилгаан хангамжийг одоо байгаа цахилгаан дамжуулах сүлжээг сайжруулах, дэд станц барих, тоног төхөөрөмжийг шинэчлэх замаар шийдвэрлэнэ.

Шинэ хотхон, хорооллын дулаан хангамжийг шийдвэрлэхдээ дулааны эх үүсвэрийг шинээр барьж хэсэгчилсэн болон төвлөрсөн

байдлаар хангах, одоо байгаа системийн дулааны алдагдлыг бууруулах замаар хангахаар тооцож байна. Баянголын ам, Улаанбаатар хотын Шинэ төв болон Яармаг шинэ хотхоны дулаан хангамжийг төвлөрсөн байдлаар шийдвэрлэхээр судалгаа хийж байна./Шинэ хорооллын дэд бүтцийн асуудлыг Дэд бүтэц гэсэн хэсэгт тодорхой тусгасан болно./

3.5. Зорилт 3. Шинэ хотхон, хорооллыг барина.

Хүснэгт 7. Газар олголтын байдлаар Улаанбаатар хотод нэвтрэн сайжруулах чиглэлээр олгогдсон газар, баригдсан орон сууц

№	2000		2001		2002		2003		2004		2005		2006		Бүгд		
	Байршил	Газартайн 100	Орон сууцны 100	Газартайн 100	Орон сууцны 100	Газартайн 100	Орон сууцны 100	Газартайн 100	Орон сууцны 100	Газартайн 100	Орон сууцны 100	Газартайн 100	Орон сууцны 100	Газартайн 100	Орон сууцны 100	Газартайн 100	Орон сууцны 100
1	Баянгол	8	110	24	1018	43	2905	11	431	3	596	4	297	7	380	100	5737
2	Баянзүрх	5	516	20	2273	23	1401	25	1579	2	192	6	229	17	1012	98	7202
3	Сонгинохайрхан	2	250	4	1731	7	1026	2	146	1	108	-	-	3	228	19	3489
4	Сүхбаатар	2	96	12	641	17	835	9	520	2	72	6	246	1	72	49	2482
5	Хан Уул	6	507	4	53	16	3325	6	1110	3	150	2	280	4	278	41	5653
6	Чингэлтэй	1	6	2	120	15	939	8	294	1	48	2	59	4	62	33	1528
	Нийт	24	1485	66	5836	121	10431	61	4080	12	1166	20	1111	36	1982	340	26091

Хүснэгт 8. Ашигт малтмал ороон орон сууц

№	2000		2001		2002		2003		2004		2005		2006		Бүгд		
	Байршил	Газартайн 100	Орон сууцны 100	Газартайн 100	Орон сууцны 100	Газартайн 100	Орон сууцны 100	Газартайн 100	Орон сууцны 100	Газартайн 100	Орон сууцны 100	Газартайн 100	Орон сууцны 100	Газартайн 100	Орон сууцны 100	Газартайн 100	Орон сууцны 100
1	Баянгол	84	272	412	120	410	1	1054	359	359	1203	336	274	336	1591	1591	1591
2	Баянзүрх	66	31	-	-	-	-	113	113	189	360	541	2058	333	333	333	333
3	Сонгинохайрхан	96	264	36	125	36	312	312	96	684	573	170	1096	1096	1096	1096	1096
4	Сүхбаатар	127	38	60	24	24	158	76	388	76	388	1709	10549	10549	10549	10549	10549
5	Хан Уул	6	1077	729	1478	2092	3085	1709	10549	10549	10549	10549	10549	10549	10549	10549	10549
6	Чингэлтэй	379	1077	729	1478	2092	3085	1709	10549	10549	10549	10549	10549	10549	10549	10549	10549
	Нийт	379	1077	729	1478	2092	3085	1709	10549	10549	10549	10549	10549	10549	10549	10549	10549

Хүснэгт 9. Улаанбаатар хотод баригдаж байгаа болон цаашид баригдах боломжит орон сууцны тоо

№	Байршил	Баригдаж байгаа болон баригдаагүй орон сууц		2009 он хүртэл баригдах боломжит орон сууцны тоо	
		Баригдаж байгаа орон сууцны тоо	Баригдаагүй орон сууцны тоо	Баригдаж байгаа орон сууцны тоо	Нийт
1	Баянгол	3100	3100	4041	4041
2	Баянзүрх	1783	3628	6107	6107
3	Сонгинохайрхан	117	3039	3156	3156
4	Сүхбаатар	4736	4736	5595	5595
5	Хан Уул	1898	2659	4908	4908
6	Чингэлтэй	1025	1025	1467	1467
	Нийт	12659	9526	22185	25274

4.2. Зорилт 2. Төв, суурин газарт нягтрал сайжруулах замаар орон сууц барина.

Засгийн газрын бондын хөрөнгө болон улсын төсвийн санхүүжилтээр бүлэг суурингийн төвд 280, аймгийн төвд 982, сумын төвд 1304 орон сууц барих ба хувийн салбарын хөрөнгө оруулалтаар 1900 гаруй орон сууцыг барина.

Төв, суурин газруудын хувьд орон сууц барих үйл ажиллагааг хоёр үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Мастер төлөвлөгөөний эхний шатанд

Хүснэгт 10. Аймаг, сумын төвд бондын хөрөнгөөр баригдах орон сууц

Д/д	Аймгийн нэр	Аймгийн төв	Сумын төв	Бүгд
1	Архангай	40	72	112
2	Баян-Өлгий	40	48	88
3	Баянхонгор	80	76	156
4	Булган	136	64	200
5	Говь-Алтай	40	72	112
6	Говьсүмбэр	40	12	52
7	Дархан-Уул	40	16	56
8	Дорноговь	40	60	100
9	Дорнод	40	56	96
10	Дундговь	46	60	106
11	Завхан	40	92	132
12	Орхон	40	8	48
13	Өвөрхангай	40	76	116
14	Өмнөговь	40	60	100
15	Сүхбаатар	40	52	92
16	Сэлэнгэ	40	68	108
17	Төв	40	108	148
18	Увс	40	76	116
19	Ховд	40	68	108
20	Хөвсгөл	40	92	132
21	Хэнтий	40	68	108
	Нийт	982	1304	2286

Хүснэгт 11. Нягтрал сайжруулах чиглэлээр 2006-2009 онд барих орон сууцны тоо

Байршил	Орон сууцны тоо	2006 (25%)	2007 (30%)	2008 (30%)	2009 (15%)
Улаанбаатарт	15255	3765	4600	4600	2290
Аймгийн төв, сумдад	4745	710	1400	1400	1235
Нийт	20000	4475	6000	6000	3525

5. Стратеги-3. Гэр хорооллыг хөгжүүлнэ.

Энэ зорилт үйл ажиллагааны хүрээнд:

5.1. Энд дор дурдсан зорилтыг тавьж байна:

-зорилт 1. гэр хорооллын дэд бүтцийг байгуулна;

-зорилт 2. гэр хорооллын амьдрах орчинг сайжруулах олон нийтийн оролцоотой бичил төслийг хэрэгжүүлнэ;

-зорилт 3. хямд өртөгтэй, дулааны хэмнэлттэй амины орон сууц барина.

5.2. Гэр хорооллын инженерийн хангамж, орон сууцны нөхцөл, амьдрах орчныг сайжруулахад

чиглэсэн төсөл, хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. Энэ чиглэлээр 93.38 сая ам.долларын өртөгтэй зээлийн 4 төсөл, 26.61 сая ам. долларын өртөгтэй буцалтгүй тусламжийн 8 төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

5.3. Дотоодын хөрөнгө оруулалтаар нийт 19.6 тэрбум төгрөг, 2006 онд 5.2 тэрбум төгрөгөөр гэр хорооллыг цэвэр, бохир усны шугам сүлжээнд холбох, цэвэр, бохир усны гол шугам, коллектор, усан сан, насосны станц, хөрсний уснаас хамгаалах барилга байгууламж барих, цахилгаан эрчим хүчээр хангах, гудамж, замын гэрэлтүүлэг, тохижилт, явган зам тавих зэрэг ажлыг хийнэ /хүснэгт 12/.



5.10. Гэр хорооллын орчинг сайжруулах төслийн үр дүнд суурилан төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагууд хороо, багийн түвшний олон нийтийн үүсгэл, санаачилгыг дэмжих замаар гэр хорооллын дэд бүтэц, нийтийн эзэмшлийн талбай, цэвэр, бохир ус, хог хаягдлын

менежментийг сайжруулахад хөрөнгийн дэмжлэг үзүүлдэг тогтолцооны эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

5.11. Загвар төслүүдийн туршлага дээр тулгуурлан 2009 онд "Гандан" хорооллын төслийг хэрэгжүүлнэ /хүснэгт 20 /.

Хүснэгт 20. Гандан хорооллын дэд бүтцийн хөрөнгийн баримжаа тооцоо

Д/д	Нэр	Өрх	Ажил				Төсөвт өртөг /сая төг/
			ОСХ, судалгаа /сая төг/	Техникийн төсөл /сая төг/	Дэд бүтэц /сая төг/	Тохижолт /сая төг/	
1	Гандан	1381	10	20.0	1130.0	1000.0	2160.0

5.12. Зорилт 3. Хямд өртөгтэй, дулааны хэмнэлттэй орон сууц барина. Энэ зорилтын хүрээнд:

-цэвэр, бохир усны төвлөрсөн болон бие даасан шугам сүлжээнд холбогдох нөхцөл бүрдсэн 4400 өрхийг баталгаажсан зураг төслөөр амины орон сууцаа барих, сайжруулах үйл ажиллагааг дэмжих;

-дэд бүтцийн анхан шатны системд холбогдсон 2120 өрхийг баталгаажсан зураг төслөөр амины орон сууцаа барих, сайжруулах үйл ажиллагааг дэмжих.

5.13. Хүрэх үр дүн:

-гэр хорооллын цэвэр усны шугам сүлжээнд холбогдсон айл өрхийн усны нэгж хэрэглээ 80л/х, 1 хүний усны хэрэглээ 20 л/х болно;

-гэр хороололд 2009 он гэхэд 10120 амины орон сууц эзэлээр баригдсан байна /хүснэгт 21/;

-гэр хорооллын амьдрах орчин сайжирснаар ядуурал буурна.


Хүснэгт 21. Гэр хороололд шинээр баригдах орон сууцны тоо

Д/д	Санхүүжүүлэх эх үүсвэр	2007		2008		2009		Нийт	
		Улаанбаатар хот	Төв, суурин газарт	Улаанбаатар Хот	Төв, суурин газарт	Улаанбаатар хот	Төв, суурин газарт	Улаанбаатар хот	Төв, суурин газарт
1	Бондын санхүүжилтээр	-	-	-	-	-	-	-	-
2	Улсын төсвөөс	2270	-	-	-	-	-	2270	-
3	Дотоодын хувийн салбарын хөрөнгө оруулалт, орон сууцны зээлээр	-	-	3000	970	3000	880	6000	1850
Дүн		2270	-	3000	970	3000	880	6270	1850
НИЙТ		-	-	-	-	-	-	-	10120

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ
 "40000 ОРОН СУУЦ" АЖААЛБАРЫГ ХАРАГЖУУЛАХ
 МАСТЕР ТУСЛАХААР

СТРАТЕГИ 3 ГЭР ХОРООВЫГ ХӨГЖҮҮЛЭХ
 ЗОРИЛТ 1.7-р АРСООЛЫН ДАВТУУЦЫГ БАЙГУУЛАХ

2А



ТАНИХ ТЭМДЭГЛЭГЭЭ



Хотын хорио



Хотын хорио дотор өргөн замын тусламж



Хотын хорио дотор өргөн замын тусламж

Хотын хорио дотор өргөн замын тусламж



Хотын хорио дотор өргөн замын тусламж

Хотын хорио дотор өргөн замын тусламж

6. Стратеги-4. Зорилт, үйл ажиллагаа:
Орон сууцны хөрөнгийн зах зээлийн харилцааг хөгжүүлнэ.

Энэ зорилтын хүрээнд:

6.1. Энэ стратегийн хүрээнд 2009 он хүртэлх хугацаанд шинээр ашиглалтад орох орон сууцанд нийгмийн эмзэг бүлэг, төрийн албан хаагчдад илүү хүртээмжтэй байдлаар хамрагдах бололцоог бүрдүүлнэ. Нийгмийн тодорхой хэсгийг зээлийн бодлогоор дэмжин орон сууцтай болгох, тодорхой хэсгийг түрээсийн орон сууцаар хангах арга замыг хөгжүүлнэ.

6.2. Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ арилжааны банкуудтай хамтран орон сууцны зээлийн тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр ажиллаж, эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.

6.3. Арилжааны банкуудтай хамтран ажиллаж, санхүүгийн дараахь хөшүүргийг ашиглан орон сууцны зээлийг хөгжүүлэхэд шаардагдах эх үүсвэрийг бүрдүүлнэ. Үүнд:

-гадаад орнуудаас орон сууц худалдан авахаар гуйвуулж байгаа мөнгөн урсгалыг санхүүгийн зөв механизм ашиглан орон сууцны санхүүжилтэд оруулах;

-орон сууцны анхдагч зах зээл дээр гаргасан 42.9 тэрбум төгрөгийн зээлийг дахин санхүүжүүлэх;

-төрийн албан хаагчдад орон сууц худалдан авахад нь зориулан бондын эх үүсвэрээс 17.6 тэрбум төгрөгийг тооцоолох.

6.4. Орон сууцны хөрөнгийн зах зээлийн харилцааг хөгжүүлэх стратегийн хүрээнд дараахь зорилтыг тодорхойлж байна:

-зорилт 1. орон сууцны зээл, хадгаламжийн тогтолцоо бий болгох;
 -зорилт 2. түрээсийн орон сууцны тогтолцоо бий болгох;
 -зорилт 3. орон сууцны барилгын өртөг зардал, үнийг бууруулах.

6.5. Зорилт 1. Орон сууцны зээл, хадгаламжийн тогтолцоо бий болгох зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

-орон сууцны зээл, хадгаламжийн эрх зүйн орчинг бүрдүүлэх;

-орон сууцны зээл, хадгаламжийн санг бүрдүүлэх;

-төрийн албан хаагчдад орон сууцны зээл олгох.

6.6. Илстэйгээр баталгаажсан үнэт цаасны зах зээлийн тухай багц хуулийн төслийг шинээр боловсруулж, үүнтэй уялдуулан 20 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна.

6.7. Орон сууцны зах зээлийг хөгжүүлэхэд татварын таатай орчин бүрдүүлэх, тухайлбал орон сууцны урт хугацаатай зээл авсан иргэдэд зээлийн хүүд төлж байгаа мөнгөн дүнг хүн амын орлогын албан татвараас чөлөөлөх, орон нутагт орон сууцны зах зээлийг хөгжүүлэхэд зориулан орон нутгийн бондыг гаргах, мөн бондын хүүг албан татвараас чөлөөлөх асуудлыг энэ ажлын хүрээнд шийдвэрлэнэ.

6.8. Орон сууцны зээлийн эх үүсвэрийг дараахь байдлаар бүрдүүлэх бөгөөд энэ хүрээнд боломжит эх үүсвэрийг 2007 оны эцэст шийдсэн байна. Үүнд:

-Азийн хөгжлийн банкны Орон сууцны санхүүжилтийн төслийн хүрээнд олгосон 16.0 тэрбум төгрөгийн зээлийг багцлан зарах замаар 10 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг бий болгоно;

-БНСУ-д ажиллаж байгаа иргэд орон сууц худалдан авахаар зөвхөн нэг жилд Монгол Улс руу гуйвуулж байгаа 160 гаруй сая ам.долларын хөрөнгийг орон сууцны зээлийн эх үүсвэр болгон ашиглана;

-60.0 тэрбум төгрөгийн Засгийн газрын бонд арилжаалах замаар түүний тодорхой хэсгийг төрийн албан хаагчдад урт хугацааны зээл болгон олгоно.

6.9. Орон сууцны урт болон дунд хугацааны зээлийн тогтолцоог арилжааны банкуудтай хамтран хөгжүүлнэ.

6.10. Зорилт 2. Түрээсийн орон сууцны тогтолцоо бий болгоно:

-түрээсийн орон сууцны эрх зүйн орчинг бүрдүүлэх;

-түрээсийн орон сууцыг барих, ашиглах тогтолцоог бий болгох.

6.11. Түрээсийн орон сууцны зах зээлийг хөгжүүлэхэд чиглэсэн эрх зүйн орчинг бүрдүүлнэ. Төрийн албан хаагч, бага, дунд орлоготой иргэдэд зориулсан түрээсийн орон сууц барих хөрөнгийн эх үүсвэрийг жил бүр улсын болон орон нутгийн төсвөөс орон сууц хөгжүүлэх санд төвлөрүүлнэ.

6.12. Гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтаар баригдах шинэ хотхон, хорооллуудад бага, дунд орлоготой иргэдийг орон сууцаар хангах бодлогыг хэрэгжүүлэх үүднээс шинэ хотхон, хороололд баригдах орон сууцны тодорхой хувийг төр хөнгөлөлттэй үнээр худалдан авах эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

6.13. Засгийн газрын санхүүжилт болон олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын зээл, тусламжийн хөрөнгөөр бага, дунд орлоготой иргэдийн орон сууцны хангамжийг сайжруулах төслүүдийг хэрэгжүүлнэ. 2009 он гэхэд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 5050 түрээсийн орон сууцны Улаанбаатар хот болон төв, суурин газарт барина.

6.14. Орон сууцны түрээсийн үйлчилгээг иргэдэд хүргэнэ.

6.15. Зорилт 3. Орон сууцны барилгын өртөг зардал, үнийг бууруулна:

-барилгын материалыг оновчтой сонгох, дулаан тусгаарлах өндөр чадвартай, өртөг хямд шинэ материал, техник, технологийг нэвтрүүлнэ;

-барилга ашиглалтад оруулах хугацааг богиносгоно;

-орон нутгийн барилгын материал, түүхий эдийн үйлдвэрлэлийг бий болгоно;

-орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлнэ.

7. Стратеги-5. Барилгын материалын үйлдвэрлэл, ажиллах хүчний чадавхийг дэмжинэ.

Энэ зорилт, үйл ажиллагааны хүрээнд:

7.1. "40000 орон сууц" хөтөлбөрийн хүрээнд барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, орчим үеийн, эрчим хүчний хэмнэлттэй техник, технологи, өртөг хямдтай материал нэвтрүүлэн ашиглалтын үеийн зардлыг бууруулах нэгдсэн бодлогыг хэрэгжүүлж барилгын салбарт шинээр бий болж байгаа ажлын байрыг өндөр чадвартай мэргэжлийн боловсон хүчнээр хангах тогтолцоог бий болгоно. Үүний тулд дараахь зорилтуудыг тодорхойлж байна:

-зорилт 1. Барилгын материалын жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, шинэ техник, технологи, материал нэвтрүүлэх (экологийн асуудал, эрчим хүчний хэмнэлттэй байх, зардал багатай байх зэргийг харгалзсан);

-зорилт 2. Барилгын салбарт мэргэжилтэй ажилтан бэлтгэх үйл ажиллагааг дэмжих;

-зорилт 3. Орон сууцны чанар, түүний хяналтын тогтолцоог боловсронгуй болгох.

7.2. Зорилт 1. Барилгын материалын жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, шинэ техник технологи, материал нэвтрүүлэх. Энэ зорилтын хүрээнд дараах асуудлыг шийдвэрлэнэ:

-орон нутгийн эдийн засгийн чадавхи, хэрэгцээ, байгаа эрдэс түүхий эдийн нөөцөд тулгуурлан уян хатан технологитой, жижиг,

дунд барилгын материалын үйлдвэрүүдийг бүс нутаг, аймгийн төвд хөгжүүлэх;

-барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих тогтолцоог бий болгох, жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, зээлийн таатай орчин бүрдүүлэх;

-импортыг орлохуйц барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх арга механизмыг боловсруулах;

-шохой, элс, хайрга, шавар зэрэг барилгын материалын үндсэн түүхий эдийг байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр ашиглах, нөхөн сэргээлт явуулдаг зарчим баримталж хэвшүүлэх;

-барилгын хог хаягдлыг зайлуулах асуудлыг шийдвэрлэх, дахин боловсруулалт хийх;

-барилгын техник, тоног төхөөрөмжийг түрээслэх, лизингээр ашиглах нөхцөлийг бүрдүүлэх.

7.3. Шинэ техник, технологийг нэвтрүүлэх чиглэлээр "40000 орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараахь ажлуудыг хийнэ:

-хямд төсөр, дулаан тусгаарлалт сайтай хашлага хийц, бүтээц, материалаар барих амины орон сууцны нэг маягийн зураг төслөөр хангах, угсралтын технологи боловсруулж, сурталчилна;

-төвөөс алслагдсан бүс нутагт барих хямд төсөр орон сууцны стандарт, норм, дүрэм боловсруулна;

-төвлөрсөн шугам сүлжээнд холбогдох боломжгүй орон сууцанд эдийн засгийн хувьд хэмнэлттэй, халаалт, цэвэр бохир ус, сэргээгдэх эрчим хүчний (нарны коллектор, дулааны нэос, дулаан, цахилгааны жижиг станц, шөнийн нөөцлүүрсн халаалт, төвлөрсөн бүс жижиг цэвэрлэх байгууламж, шахмал болон биомассын түлш, ус, цахилгааны хэрэглээг бууруулах г.м) асуудлыг зураг төслөөр дамжуулан нэвтрүүлнэ;

-зураг төслийн ажилд шинэ техник, технологи, хийц бүтээц, материал тусгах ажлыг бодлогоор дэмжин, зураг төсөл, хот төлөвлөлтийн мэргэжилтэн, архитектор, инженерүүдийн тодорхой хэсгийг гадаадын төсөл, хөтөлбөрийн хүрээнд хамруулж сургах, давтан сургах асуудлыг шийдвэрлэнэ;

-одоо байгаа дулаан, техникийн норм, стандартыг олон улсын түвшинд нийцүүлэн боловсронгуй болгоно.

7.4. Шинээр барих болон шинэчлэх шаардлагатай барилгын материалын үйлдвэрүүдийг орон нутагт байгаа эрдэс түүхий эдийн нөөцөд тулгуурлан бүс нутагт хөгжүүлнэ.

Хүснэгт 22. Үндсэн материалын хэрэгцээ, хангамж нийлүүлэлт (40000 орон сууц, хөтөлбөр)

Д/д	Материал	х/н	Нэг сууцанд ноогдох хэрэгцээ (35м ²)	Хэрэгцээ хангамж (жиглээр)												Тайлбар
				2006			2007			2008			2009			
				Хэрэгцээ	Хангамж*	Хэрэгцээ	Хангамж*	Хэрэгцээ	Хангамж*	Хэрэгцээ	Хангамж*					
1	Цагамент	тн	7 426,00	745 000,00	60 304,00	745 000,00	52 609,00	745 000,00	66 737,00	745 000,00	Хангалттай					
2	Шэхэй	м ³	0,74	115 000,00	8 002,36	115 000,00	9 228,54	115 000,00	8 648,38	115 000,00	Хангалттай					
3	Элс	м ³	13,13	73 120,97	625 000,00	141 987,82	625 000,00	163 744,23	625 000,00	153 450,31	625 000,00					
4	Хайрга	м ³	9,26	51 568,94	3 710 000,00	100 137,64	3 710 000,00	115 481,46	3 710 000,00	108 221,62	3 710 000,00					
5	Тоосго	м/ш	6284	2 942,00	14 650,00	5 714,00	14 650,00	6 689,00	14 650,00	6 175,00	14 650,00					
6	Арматур	тн	1,47	8 186,43	132 700,00	15 896,58	132 700,00	18 332,37	132 700,00	17 179,89	132 700,00					
7	Бетон, т/б, эрлэхүүн	м ³	3,31	18 433,39	328 000,00	35 794,34	328 000,00	41 279,01	328 000,00	38 683,97	328 000,00					
8	Мэдэн материал	м ³	4,40	24 503,60	9 445,00	47 581,60	9 445,00	54 872,40	9 445,00	51 422,80	9 445,00					
9	Дулаалгын материал	м ³	4,44	24 698,52	82 000,00	47 960,09	82 000,00	55 308,89	82 000,00	51 831,85	82 000,00					
10	Цэнх	ш	1,81	10 079,89	102 500,00	19 573,34	102 500,00	22 572,51	102 500,00	21 153,47	102 500,00					
11	Хаалга	ш	3,68	20 493,92	39 000,00	39 796,52	39 000,00	45 893,28	39 000,00	43 008,16	39 000,00					
12	Гилсэн хэвтэн	м ²	24,30	135 326,70		262 780,20		303 904,30		283 994,10	импортоор					
13	Цонхны шил	м ²	6,24	34 750,56		67 479,36		77 819,04		72 926,88	импортоор					
14	Хар цаас	м ²	12,37	68 888,53		133 769,18		154 266,27		144 568,19	импортоор					
15	Дээврийн хучлагын материал	м ²	8,05	44 830,45		87 062,70		100 991,55		94 080,35	импортоор					
16	Кэрэмж хавтанцар	м ²	18,40	102 469,60				198 977,60		229 466,40	215 040,80					

* 2005 оны судалгаа, суурингдсан хүчин чадлаар тооцов

7.5. Зорилт 2. Барилгын салбарт мэргэжилтэй ажилтан бэлтгэх үйл ажиллагааг дэмжих. Энэ зорилтын хүрээнд дараахь асуудлыг шийдвэрлэнэ:

-барилгын салбарыг мэргэжилтэй ажилчдаар хангах, ажлын байр нэмэгдүүлэх дэд хөтөлбөрийг холбогдох яамдтай хамтран боловсруулна;

-барилгын салбарын мэргэжилтэй ажилчид дунд мэргэжлийн боловсон хүчинг бэлтгэх сургалтын байгууллагын техник хангамж, сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох, багшлах боловсон хүчний чадавхийг дээшлүүлнэ;

-хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн албан бус зайны болон түр сургалтын тогтолцоог хөгжүүлнэ;

-мэргэжлийн сургалтыг дэмжих нийгмийн түншлэлийг хөгжүүлэх, ялангуяа мэргэжлийн сургалтад ажил олгогчдын орлоцоо, хөрөнгө оруулах сонирхлыг дэмжих зорилгоор эдийн засгийн хөшүүрэг бий болгох асуудлыг судална;

-барилгын салбарын зарим мэргэжлийн сургалтын байгууллагаас өөрсдийн сургалтын бааз, ажлын туршлагыг түшиглэн "Барилгын салбарын мэргэжлийн сургалт, арга зүйн төв" байгуулах санал санаачилгыг дэмжиж, хамтран ажиллана;

-барилгын салбарын ажиллагсдыг мэргэшүүлэх, магадлан итгэмжлэх, мэргэжлийн зэрэг олгох үндэсний тогтолцоог холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран бий болгоно;

-ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийн барилгын чиглэлийн мэргэжил эзэмших сонирхлыг дэмжих хөшүүрэг бий болгох асуудлыг судална;

-барилгын салбарт дутагдалтай байгаа мэргэжилтэй ажилчдыг богино хугацаанд бэлтгэх зорилгоор салбарын мэргэжилтэй ажилчид бэлтгэнэ;

"40 000 орон сууц" хөтөлбөрийн хүрээнд зах зээлийн эрэлт хэрэгцээний судалгааг үндэслэн барилгын эрэлт хэрэгцээ ихтэй түгээмэл мэргэжлийг эзэмшүүлнэ;

"40 000 орон сууц" хөтөлбөрийн хүрээнд төсвийн санхүүжилтээр баригдах орон сууцны барилгын гүйцэтгэгч компани, сургалтын байгууллагатай гурван талын гэрээ байгуулах

замаар түр сургалтад хамрагдсан хүмүүсийг ажлын байраар хангах, талбайн дадлага, сургалт хийх боломжийг бүрдүүлнэ.

7.6. Зорилт 3. Орон сууцны чанар, түүний хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно. Энэ зорилтын хүрээнд дараахь асуудлыг шийдвэрлэнэ:

-орон сууц барих техникийн нөхцөл, экспертиз, орон сууцыг барьж эхлүүлэх, дуусгаж улсын комисс хүлээн авах тогтолцоог боловсронгуй болгож нэг цэгийн үйлчилгээг нэвтрүүлнэ;

-барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх "тусгай зөвшөөрөл" (лицензийг) олгодог журамд шилжих, стандартчилал, тохирлын гэрчилгээ, үйлдвэрлэлийн болон хөндлөнгийн хяналтын систем, итгэмжлэгдсэн барилгын материалын лаборатори, сорил шинжилгээний ажлын үр дүнг баталгаажуулах, технологийн зааврын мөрдөлт, бүтээгдэхүүний чанарын сертификат, мэдээллийн сүлжээг бий болгоно;

-хүний эрүүл мэнд, ахуйд хортой, баталгагүй материал, эдлэхүүн хил нэвтрэхээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор хойд ба урд хилийн боомт дээр барилгын материалын чанарын баталгаажуулалтын итгэмжлэгдсэн лаборатори байгуулах, мэргэжлийн хяналтын байцаагч ажиллуулах асуудлыг шийдвэрлэнэ;

-чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг урамшуулах, сурталчлах ажлыг зохион байгуулна;

-стандартчилал, барилгын норм, норматив, үнэ бүрдлийн тогтолцоог олон улсын түвшинд хүргэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

7.7. Хүрэх үр дүн:

-орон сууцны 1м² талбайн одоогийн өртөг 10-15 хувиар буурна;

-дотоодын зах зээлээс хангах бололцоотой барилгын материалын үйлдвэрлэл "40000 орон сууц" хөтөлбөрийг бүрэн хангах түвшинд хүрсэн байна;

-барилгын салбарт ажиллагсдын тоо 25 хувиар өссөн байна;

-эрэлт хэрэгцээг хангах мэргэжилтэй ажилчдыг бэлтгэх тогтолцоо боловсронгуй болно;

-чанарын хяналтын тогтолцоо боловсронгуй болно.

Төвдугаар стратегийн хэвсрэлт
 Хүснэгт 23 Шинээр барих, шинэчлэх барилгын материалын үйлдвэрийн байршил

Д/д	Бүсийн нэр	Үйлдвэрийн нэр	х/н	Тоо	Хүчин чадал	Байршил	Шаардлагтай ойролцоо хөрөнгө оруулалт* /сая төгрөг/	Тайлбар
1	Баруун бүс	Керамик, тоосгоны үйлдвэр	сая шир	2	32.0	Увс, Говь-Алтай	387.0	Алтайд байгааг шинэчилнэ
		Хөнгөн ба хөөсөн бетоны үйлдвэр	мян м ³	4	25.0	Ховд, Өлгий, Улаангом, Улиастай	1233.0	Шинээр барих
		Цементийн үйлдвэр	мян тн	1	10-15	Ховд	776.0	Ховдод барьж дуусгах
		Цементийн үйлдвэр	мян м ³	1	2500.0	Алтай	2500.0	Алтайд шинээр барина
		Төмөр бетоны үйлдвэр	мян м ³	5	50.0	Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан, Говь-Алтай	225.0	Хэсэгчлэн болон бүрэн шинэчлэх
2	Хангайн бүс	БҮГД		13			5121.0	
		Хөнгөн ба хөөсөн бетоны үйлдвэр	мян м ³	2	10.0	Булган, Мөрөн, Улиастай, Цэцэрлэг	477.0	Булган, Хөвсгөлд шинээр, Цэцэрлэг, Баянхонгорт байгааг шинэчлэнэ
		Төмөр бетоны үйлдвэр	мян м ³	5	65.0	Хөвсгөл, Баянхонгор, Өвөрхангай, Орхон, Архангай	285	Хэсэгчлэн болон бүрэн шинэчлэх
		Хийжүүлсэн царууц бетон	мян м ³	1	25.0	Эрдэнэт	875.0	Шинээр барих
		Хурмуц бетон гулдмай	сая ж/т	2	15.0	Цэцэрлэг, Баянхонгор	541.0	Хэсэгчлэн шинэчлэх
3	Төвийн бүс	БҮГД		10			2178.0	
		Керамик, тоосгоны үйлдвэр	сая шир	1	2.5-3.0	Дундговь	67.0	Шинээр барих
		Гөлтөнгий үйлдвэр	мян тн	1	15-20.0	Дундговь	178.0	Шинээр барих
		Төмөр бетоны үйлдвэр	мян м ³	3	10.0	Эрдэнэт, Сайншанд, Мандалговь	732.0	Барьж дуусгах
		Байшин үйлдвэрлэх комбинат	мян м ³	1	70.0	Дархан	1250.0	Өөрчлөлт шинэчлэлт хийх
		Пөрөлтийн үйлдвэр	мян м ³	1	30-50.0	Дорноговь	182.0	Өөрчлөлт шинэчлэлт хийх
		Царууц тоосгоны үйлдвэр	сая шир	1	27.0	Дархан	650.0	Өөрчлөлт шинэчлэлт хийх

4	Цемент шохойн үйлдвэр	Хурман бетон гүлдэмэй	мян м ³	1	500.0	Хөтөл	12500.0	Өөрчлөлт шинэчлэлт хийх	
		Хурман бетон гүлдэмэй	сая ж/т	1	4.5	Даланаадагд	123.0	Хэсэгчлэн шинэчлэх	
	БҮГД	Керамзитын үйлдвэр	мян м ³	1	220.0	Дархан	650.0	Шинэчлэх, сэргээх	
		Эрдэс хөвөнгийн үйлдвэр	мян м ³	1	60.0	Дархан	560.0	Хэсэгчлэн шинэчлэх	
	Зүүн бүс	Төмөр бетоны үйлдвэр	Төмөр бетоны үйлдвэр	мян м ³	3	20.0	Өндөрхаан, Чойбалсан, Сүхбаатар	16892.0	
			Цементийн үйлдвэр	мян тн	1	15-20.0	Хэнтий	2380.0	Барьж дуусгах Шинээр барих
		Хөнгөн ба хөрсөн бетоны үйлдвэр		1		Баруун-Урт	197.0	Өөрчлөлт шинэчлэлт хийх	
		Царууд тоосгоны үйлдвэр	сая шир	1	33.0	Чойбалсан	780.0	Өөрчлөлт шинэчлэлт хийх	
		Хурман бетон гүлдэмэй	сая ж/т	1	4.5	Баруун-Урт	197.0	Хэсэгчлэн шинэчлэх	
		БҮГД			7			4026.0	
5	Хийжүүлсэн бетоны үйлдвэр	Хийжүүлсэн бетоны үйлдвэр	мян м ³	1	45.0	Улаанбаатар	415.0	Хэсэгчлэн шинэчлэх	
		Ган хийцийн үйлдвэр	мян м ³	1	25.0	Улаанбаатар	725.0	Өөрчлөлт шинэчлэлт хийх	
	УБ бүс	Перлитийн үйлдвэр	мян м ³	1	30-50.0	Улаанбаатар	176.0	Шинээр барих	
		Төмөр бетоны үйлдвэр	мян м ³	1	40.0	Улаанбаатар	527.0	Өөрчлөлт шинэчлэлт хийх	
	БҮГД	Хавтгай шилний үйлдвэр	мян м ²	1	1500.0	Улаанбаатар	3875.0	Шинээр барих	
		Керамик тоосгоны үйлдвэр	мян м ³	1	90.0	Улаанбаатар	1120.0	Өөрчлөлт шинэчлэлт хийх	
	БҮГД ДҮН			6				6838.0	
				48				35055.0	

*Монгол улсын барилгын салбарыг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг үндэслэл болгов.

Хүснэгт 24. Барилгын материалын жижиг, дунд үйлдвэрийг 2006-2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэл*

Д/д	Барилгын материалын үйлдвэрийн нэр	Байршил	х/н	Хүчин чадал	Тайлбар
1	Цементийн жижиг үйлдвэр	Дорноговь, Хэнтий	мян.тн	15-20	Шинээр барих
2	Перлитийн үйлдвэр	Улаанбаатар	мян.м ²	30-50	Шинээр барих
3	Хөвсөн бетон эдлэхүүний үйлдвэр	Ховд, Сүхбаатар, Завхан, Дорнод, Баян-Өлгий, Сэлэнгэ	мян.м ³	2-5	Шинээр барих
4	Өнгөлгөөний тоосгоны үйлдвэр	Төмөр замын дагуухь бүсэд	сая шир	5.0	Шинээр барих
5	Орон нутгийн жижиг төмөр бетон эдлэхүүний үйлдвэр	Хөвсгөл, Булган, Завхан, Баян-Өлгий, Баянхонгор, Дорнод, Өмнөговь, Увс, Ховд	мян.м ³	3-5	Шинэчлэн өөрчлөх, шинээр барих
6	Орон нутгийн жижиг хүрмэн блокны үйлдвэр	Баянхонгор, Архангай, Булган, Өмнөговь, Хөвсгөл	мян.м ³	3.0 хүртэл	Сэргээх, шинээр барих
7	Орон нутгийн тоосгоны үйлдвэр	Баянхонгор, Алтай, Хэнтий, Дорноговь, Дундговь, Өмнөговь	сая шир	2-5	Сэргээх, шинээр барих
8	Төмөр бетон эдлэхүүний үйлдвэр	Дархан	мян.м ³	10.0 хүртэл	Сэргээх, шинэчлэх
9	Эрдэс хөвөнгийн үйлдвэр	Дархан	мян.м ³	30-60	Сэргээх, шинэчлэх
10	Ховдын цементийн үйлдвэр	Ховд	мян.тн	10-15	Туршилт, тохируулга хийх

* БХБНААУТөвийн 2005-2006 оны судалгааны материалыг үндэслэл болгов.

Гурав. Дэд бүтэц

1. "40000 орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Улаанбаатар хот болон бусад төв, суурин газрын цахилгаан, дулаан, цэвэр, бохир усны барилга байгууламжийн суурь, нөөц хүчин чадал зэрэг дэд бүтцийг эхний ээлжинд шийдвэрлэх асуудал чухал юм.

2. Усан хангамж, ариутгах татуурга

2.1. Улаанбаатар хотын төвийн хэсгийн нэг ерхийн дундаж хүн амын тоог 4.2, нэг орон сууцны байрны талбайг 48 м² гэж тооцон үзэхэд цэвэр, бохир усны хоногийн хэрэглээ 21460 м³ байна. Иймд одоогийн усны эх үүсвэрийн хүчин чадал нь 2012 он хүртэл хүрэлцээтэй байна. Хүн амын механик өсөлт, усны хэрэглээ нэмэгдэхээс шалтгаарлан цаашид ус хангамжийн шинэ эх үүсвэр зайлшгүй шаардлагатай болно. Иймд усны шинэ эх үүсвэрийг хайх болон техник эдийн засгийн үндэслэлийг

боловсруулах ажлыг 2008 оноос өмнө хийх ба түүний хөрөнгийн эх үүсвэрийг улсын төсвөөс санхүүжүүлэх шаардлагатай.

2.2. Орон сууцны нягтралаар 20000 айлын орон сууц барих болон гэр хороолол, ялангуяа Гандан, 7-р хороолол, Зурагтын гэр хорооллыг бохирын шугам сүлжээнд холбоход техникийн нөхцөлийн хувьд хүрэлцээ муутай байгаа тул бохир усны 25-р коллекторыг яаралтай барих шаардлагатай байна. Улсын төсвийн 300 сая төгрөгийн санхүүжилтээр тус коллекторыг барих ажлыг 2006 онд эхлүүлж байна.

2.3. Туул-1 коллекторыг Налайхын бохирын шугамтай холбоно.

3. Дулаан хангамж

3.1. Улаанбаатар хот нь дулааны эх үүсвэрийн хувьд 1700 МВт дулааны хүчин чадал байгаа бөгөөд

үүний 1300 орчим МВт дулааны хүчин чадлыг ашиглаж байна. Одоогийн байдлаар дулааны эрчим хүчний нөөц 700 МВт байгаа юм.

3.2. Шинээр орон сууц барих нөхцөлд Улаанбаатар хотын дулааны шугам хоолойг шинэчилж өргөтгөх, дулааны хэмнэлтийн тоног төхөөрөмж, материалыг ашиглах замаар орон сууцны дулааны асуудлыг шийдвэрлэх боломжтой юм. Иймд Улаанбаатар хотод шинэ хотхон, хороолол байгуулахад 2009 он хүртэлх хугацаанд дулааны нэмэлт эх үүсвэр заавал шаардлагагүй гэж үзэж байна. Иймд Яармаг, Баянголлын ам, Улаанбаатар хотын Шинэ төв зэрэг байршлуудыг төвлөрсөн дулааны эрчим хүчээр хангах зураг төслийг 2006 онд багтаан боловсруулах, 2007–2008 онд багтаан барилга угсралтын ажлыг эхлүүлэхээр төлөвлөж байна.

3.3. Улаанбаатар хотын төвийн хэсгийн дулааны хуучирсан шугам хоолойг шинэчлэх, өргөтгөх ажлыг хийхэд зориулж нийслэлийн төсвөөс жилд 1–2 тэрбум хүртэл төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийхээр тооцож байна.

4. Цахилгаан хангамж

4.1. Нягтрал сайжруулах болон гэр хорооллын цахилгаан эрчим хүчний хангамжийг сайжруулахын тулд хотын төв хэсэгт шинээр 35/10 кВТ-ын дэд өртөө 2–ыг барих, хотын төв хэсгийн дэд станцуудыг 2 трансформатортой болгон өргөтгөх, кабель шугамуудын хөндлөн огтлолыг өргөсгөх, шинээр кабель шугам, хаалттай дэд өртөө байгуулах ажлыг 2008 он гэхэд шийдвэрлэнэ.

5. Зам тээвэр

5.1. Улаанбаатар хотын төвийн хэсгийн зам нь хуучирч эвдэрсэн, мөн үер усны хамгаалалтууд байхгүй зэрэг олон шалтгаанаар орон нутгийн замууд ачааллаа даахгүй болж байна. Орон нутгийн замыг барьж байгуулахад шинэ техник, технологийг ашиглах шаардлага хэрэгцээ ч их байна. Иймд мастер төлөвлөгөөний хүрээнд холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана.

6. Холбоо

6.1. Монгол Улсад мэдээллийн технологийн хөгжил хамгийн өндөр хурдтай хөгжиж байгаа бөгөөд цаашид Улаанбаатар хотод байгуулагдах шинэ хотхон, хорооллуудад виртуаль орчинг бий болгоход холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана.

6.2. Нийтийн зориулалттай орон сууц барих, гэр хорооллыг хөгжүүлэх асуудал нь шаардлагатай дэд бүтцийг улс, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэн барихаас шууд хамаарч байна. Иймд

орон сууцныг хөгжүүлэх санд жил бүр тодорхой хэмжээний хөрөнгийг улсын төсвийн эх үүсвэрээс дэд бүтцийг барихад зориулан төвлөрүүлж байх нь зүйтэй. Түүнчлэн орон нутаг өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр харьяа нутаг дэвсгэрийн дэд бүтцийн асуудлаа шийдэх нөхцөлд Засгийн газраас хөнгөлөлт, зээл, татаас олгох боломжийг судална.

6.3. Улсын болон орон нутгийн төсөв, хувийн салбарын санхүүжилтээр баригдах дэд бүтцийн барилга байгууламж, хөрөнгө оруулалтыг нөхөн төлөх оновчтой тогтолцоо бий болгоно.

7. Шинэ хотхон хорооллын нийгмийн үйлчилгээ

7.1. Улаанбаатар хотын захын ашиглагдаагүй байршлуудад шинэ хотхон, хорооллууд баригдахын хамт нийгмийн үйлчилгээний зориулалттай барилга байгууламжууд баригдана. Тэдгээрийн хүчин чадал, хэрэгцээ, эрүүл ахуйн болон техникийн стандарт, нормыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран шийдвэрлэнэ.

Дөрөв. Хөрөнгө оруулалт, санхүүжилт

Барилга, хот байгуулалт, газрын харилцаа, орон сууц нийтийн аж ахуйн салбарт 2005 онд урьдчилсан гүйцэтгэлээр 557.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, 196.7 тэрбум төгрөгийн барилга угсралтын ажил гүйцэтгэв. Нийт хөрөнгө оруулалтын 47.4 хувийг дотоодын, 52.6 хувийг гадаадын хөрөнгө оруулалт эзэлж байна.

Орон сууцны барилгын зураг төсөл зохиох аргачлалын дагуу хөтөлбөрийн хүрээнд баригдах дөчин мянган орон сууцны нийт төсөвт өртгийг тооцон гаргасан. Энэхүү тооцоонд үндэслэн 40000 орон сууцныг барихад шаардагдах нийт санхүүжилт, түүний эх үүсвэрийг урьдчилсан байдлаар 2009 он хүртэл тооцон, төсөвт өртөгт жилийн дундаж инфляцийн түвшинг 9.5 хувь байхаар тооцсон /Хүснэгт 25/. 40000 орон сууцны санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсөв, Засгийн газрын бонд олон улсын байгууллагын буцалтгүй тусламж, зээл болон гадаад, дотоодын хувийн салбарын хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр төлөвлөж байна.

2006 оны түвшинд нийтийн зориулалтын орон сууцны нэг метр квадратын төсөвт өртгийг 322.7 мян.төгрөгөөр тооцсон ба 50 гаруй хувийг барилгын материалын зардал эзэлж байна. Хөтөлбөрийн хүрээнд орчин үеийн техник, технологи ашиглах замаар барилгын материалын зардлыг бууруулахаар төлөвлөж байна.

40 000 орон сууц барих нийт төсөвт өртөг нь ойролцоогоор 636.7 тэрбум төгрөг буюу 543.3 сая ам.доллар орчим хөрөнгийн эх үүсвэр шаардлагатай байна. Энэ төсөвт өртөгт орон сууцны

гадна тохижилт, дулаан, инженерийн шугам сүлжээний зардлыг оруулаагүй болно.

Орон сууцны тоо, нийт талбайг гаргахдаа 1 өрөө орон сууцыг 27-35 метр квадрат, 2-3 өрөө орон сууцыг 35-45 метр квадрат, 4-өөс дээш өрөө орон

сууцыг 45-70 метр квадратаар тооцож гаргасан. Орон сууцны нэг метр квадрат зардлыг тооцохдоо "орон сууцны барилгын зураг төсөл зохиох" аргачлалын дагуу орон сууцны м.кв-ын дундаж зардлаар тооцов.

Хүснэгт 25. 2006-2009 онд барих орон сууцны төсвийн тооцоо /зардлаар мян.төг/

	Нийт зардал	2006	2007	2008	2009
Шинэ хороолол барих орон сууцны зардал: Үүнээс	167,893.0	11,128.6	18,901.7	51,926.5	85,936.1
Шинэ хороолол барих түрээсийн орон сууцны зардал	25,128.9			11,994.7	13,134.2
Нягтрал сайжруулж баригдах орон сууцны зардал: Үүнээс	300,299.4	66,139.3	86,913.0	95,169.7	52,077.5
Түрээсийн орон сууц	34,643.0	7,622.8	10,001.0	10,951.1	6,068.0
Бондын санхүүжилтээр	61,215.6	13,459.8	17,716.6	19,399.7	10,639.5
Төрийн албан хаагчдын	26,448.8	5,841.8	7,688.3	8,418.7	4,499.9
Орон сууцанд мансардын давхар нэмэх	3,406.7	750.3	985.9	1,079.5	591.0
Хувийн болон бусад эх үүсвэр	174,585.3	38,464.5	50,521.1	55,320.7	30,278.9
Гэр хорооллын орон сууцны зардал	168,551.6	13,459.8	34,491.1	49,913.4	70,687.3
Орон сууцны нийт төсөвт өртөг	636,744.1*	90,727.8	140,305.9	197,009.6	208,700.9

*40 000 орон сууцны төсөвт өртөг 636.7 тэрбум төгрөг байх урьдчилсан тооцоо гарч байна.

"40 000 орон сууц" хөтөлбөрийн хүрээнд залуу гэр бүл болон бага, дунд орлоготой иргэдийн төлбөрийн чадварт нийцэхүйц үнэ бүхий орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, тэдний төлбөрийн чадварыг дэмжсэн төрийн бодлого хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Энэхүү зорилтыг хэрэгжүүлэх үүднээс "40 000 орон сууц" хөтөлбөрийн санхүүгийн эх үүсвэрийн тодорхой хэсгийг бүрдүүлэхийн тулд Засгийн газраас дунд хугацааны 60 тэрбум төгрөгийн бонд гаргах тухай зөвшөөрлийг 2006 оны 7 дугаар сарын 6-ны өдөр Улсын Их Хурал баталсан болно.

Барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ажиллах хүчнийг бэлтгэхэд "40000 орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлэх мастер төлөвлөгөөний хүрээнд жил бүр 1.6 тэрбум улсын болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж байна. Үүний дийлэнх хувь нь жижиг, дунд үйлдвэр байгуулахад зээлийн хөнгөлөлт үзүүлэх, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн сургалтын техник хэрэгслийг шинэчлэхэд зарцуулагдана.

Орон сууцны зээлийн эх үүсвэрийг бүрдүүлэх замаар иргэдэд дунд, урч хугацааны зээл олгох механизмыг бий болгохоор мастер төлөвлөгөөний хүрээнд төлөвлөж байна. Орон сууцны зээлийн эх үүсвэрт 2009 он хүртэлх

хугацаанд нийт 221.4 тэрбум төгрөг шаардагдана. Үүнийг боломжит эх үүсвэрүүдийг хонлогдох байгууллагуудтай хамтран судлах замаар бүрдүүлэх бололцоотой гэж үзэж байна.

Дэд бүтэц

40000 орон сууц барихад шаардагдах инженерийн дэд бүтцийг байгуулах ажлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр тооцсон бөгөөд санхүүжилтийн хэлбэрийн хувьд хэд хэдэн хувилбарыг авч үзсэн. Үүнд:

- улсын салбарын санхүүжилтээр;

- гадаад эх үүсвэрээс болон хувийн салбарын хөрөнгө оруулалтаар барьж, хөрөнгийн эх үүсвэрийг тодорхой хугацааны дараа Засгийн газраас буцаан төлөх;

- улсын салбарын хөрөнгө оруулалтаар дэд бүтцийг байгуулан түүнийг барилгын байгууллагуудад худалдах.

2006-2009 он хүртэл инженерийн дэд бүтцийг барьж байгуулахад нийт 480.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардагдахаар байна /Хүснэгт 26/. Тус хүснэгтэд 2006-2009 он хүртэл инженерийн дэд бүтцийг байгуулах төсвийг харуулав. Дэд бүтцийн хөрөнгө оруулалтын дийлэнх хувь нь шинэ хотхон, хороолол байгуулах, гэр хорооллын дэд бүтцийг сайжруулахад зориулагдсан.

Хүснэгт 26. 2006-2008 онд баригдах орон сууцны дэд бүтцийн тооцоо /он, сая төгрөг/

	2006			2007			2008			2009		
	Төсвөөс	Гадаад	Хувийн	Төсвөөс	Гадаад	Хувийн	Төсвөөс	Гадаад	Хувийн	Төсвөөс	Гадаад	Хувийн
Шинэ хорооллын орон сууцны дэд бүтэц	5,000	51,900		31,360	76,000		30,000	75,300		29,445	57,520	
цэвэр, бохир усны шугам Баянголлын ам/	2,000.0			4,000.0			4,000.0			2,000.0		
Баянтөл хотхон /дулаан, цахилгаан, бусад/	1,000.0			2,360.0			2,000.0			1,000.0		
Орбит хотхон /дулаан, цахилгаан, бусад/	500.0			1,500.0			1,000.0			740.0		
ШУТИС /дулаан, цахилгаан, бусад/	500.0			1,500.0			1,000.0			410.0		
Мянганы хотхон /дулаан, цахилгаан, бусад/	1,000.0			2,000.0			2,000.0			885.3		
цэвэр, бохир усны шугам /УБ шинэ төв/				20,000.0			20,000.0			24,410.0		
цэвэр, бохир усны шугам /4 улирал цэцэрлэг/		10,000.0			25,000.0			25,000.0			2,400.0	
цэвэр, бохир усны шугам /Яармаг шинэ хотхон/		41,400.0			50,000.0			50,000.0			50,000.0	
цэвэр, бохир усны шугам /Маршал хотхон/		500.0			1,000.0			300.0			120.0	
Гэр хорооллын орон сууц	10,233.7	3,000.0		11,000.0	5,000.0		10,000.0	5,000.0		9,334.5	974.0	
104 өрхийн цэвэр бохир усны шугам	5,000.0			5000			5000			6000		
Цэвэр усны шугам /Төслүүдээс хөдөө орон нутагт хийх/		3,000.0			5000			5000			974	
цэвэр, бохир усны шугам сүлжээ /Улаанбаатар хот/	5,233.7			6000			5000			3334.5		

Нягтрал сайжруулж баригдах орон сууцны дэд бүтэц	7,500.0	7,800.0		6,800.0	2,708.0	
Хоёр, 35 кв-ын дэд станц, дамжуулах шугамын хамт	1,000.0	1200		500	500	
2 ороомогт трансформатор бүхий 110/10 кв-ын дэд станц шинээр барих	300.0	500		200	200	
Бохирын 25-р цуглуулах гол шугам	1,000.0	500		500		
Туул-1 бохир цуглуулах шугам 36 км	5,000.0	5000		5000	1408	
Улаанбаатар хотын дулааны шугам сүлжээг шинэчлэх, өргөтгөх	100.0	300		300	300	
Хотын доторхи зам сайжруулах	100.0	300		300	300	
Эх үүсвэр	3,615.0	15,000.0		15,000.0	16,442.0	
ундны шинэ эх үүсвэрийг хайх болон техник эдийн засгийн үзүүлэлтийг боловсруулах		1,000.0		1,000.0	1,000.0	
Налайхын цэвэрлэх байгууламжийг барьж байгуулах (27 км)	2,000.0	4,000.0		4,000.0	2,892.0	
Ундны усны дээд эх үүсвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх		5,000.0		5,000.0	7,550.0	
Төв цэвэрлэх байгууламжийн төлөх, төлөвлөлийн шинэчлэлт	1,615.0	6,000.0		5,000.0	5,000.0	
	26,348.7	65,160.0	81,000.0	61,800.0	80,300.0	57,029.8
дүн /сая төгрөг/						53,494.0
Нийт дүн /сая төгрөг/						480,932.5

Засгийн газрын 2005 оны 66 дугаар тогтоолын 21 дүгээр хэвсрэлт

"40000 ОРОН СУУЦ" ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга - Барилга, хот байгуулалтын сайд
 Дэд дарга - Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч
 Гишүүд - Сангийн сайд;
 -Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд;
 -Түлш, эрчим хүчний сайд;
 -Байгаль орчны дэд сайд;
 -Батлан хамгаалахын дэд сайд;
 -Боловсрол, соёл, шинжлэх ухааны дэд сайд

-Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн дэд сайд;
 -Үйлдвэр, худалдааны дэд сайд;
 -Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд;
 -Хүнс, хөдөө аж ахуйн дэд сайд;
 -Эрүүл мэндийн дэд сайд;
 -Монгол банкны тэргүүн дэд ерөнхийлөгч /зөвшилцсөнөөр/.

Нарийн бичгийн дарга - Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр

Дугаар 266

Улаанбаатар хот

Төрийн өмчит хуулийн этгээд байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Холбогдох хууль тогтоомжийн дагуу стратегийн ач холбогдол бүхий орд, улсын төсвийн хөрөнгөөр эрэл, хайгуул хийж нөөцийг нь тогтоосон ордын ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшин үйл ажиллагаа явуулах, ашигт малтмалын нөөцийн үнэлгээ хийх, ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн өмчийн оролцотой компаниудын төрийн мэдлийн хувьцааг борлуулахад зөвлөх үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг

бүхий төрийн өмчит компанийг байгуулан дүрмийг баталж ажиллуулах арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Батболд, Төрийн өмчийн хороо /Д.СУГАР/, Ашигт малтмал, газрын тосны Хэрэг эрхлэх газрын дарга Л.Болд нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

С.БАТБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр

Дугаар 267

Улаанбаатар хот

Орон сууцны үндэсний төвийг татан буулгах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Орон сууцны санхүүжилтийн корпораци" компани байгуулагдаж байгаатай холбогдуулан "Орон сууцны үндэсний төв"-ийг татан буулгасугай.

2. Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа эрхэлж буй "Орон сууцны үндэсний төв"-ийг хууль тогтоомжийн дагуу татан буулгаж, түүний үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийг зохих журмын дагуу балансаас балансад орон тоо, төсвийн хамт төрийн өмчид ногдох хувьд оролцуулан шинээр байгуулагдах "Орон сууцны санхүүжилтийн

корпораци" компанид шилжүүлэх арга хэмжээ авахыг Барилга, хот байгуулалтын сайд Ж.Наранцацралт, Сангийн сайд Н.Баяртсайхан, Төрийн өмчийн хороо (Д.СУГАР), Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Ц.Батбаяр нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

САНГИЙН САЙД

Н.БАЯРТСАЙХАН

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
САЙД

Ж.НАРАНЦАЦРАЛТ